



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Номгон сумын Ерөнхий боловсролын сургууль”-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2024/178/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
Аудит гэрээгээр гүйцэтгэсэн Ирагам аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Ц.Ариунжаргал
Утас: 70539911 Цахим хаяг: iragam.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.23 № 155
танай _____ -ны № _____ -т

НОМГОН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.БАТСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Номгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Номгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжиж буй нутгийн дэм хөтөлбөрт байгууллагын албан хаагчдыг хамруулан 138,486.3 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 50,154.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер нийлүүлэгдэж багш нарын 81 хувь шинэ техник хэрэгслээр хангагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 88.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020265

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 107,525,689.42 | 113,880,098.27 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 36,843,700.42 | 25,333,981.27 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 36,843,700.42 | 25,333,981.27 |
| 3121 | Төгрөг | 36,843,700.42 | 25,333,981.27 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 36,843,700.42 | 25,333,981.27 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 70,681,989.00 | 88,546,117.00 |
| 351 | Түүхий эд материал | 5,910,900.00 | 3,910,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,860,900.00 | 3,860,000.00 |
| 35130 | Эм боох материал | 50,000.00 | 50,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 64,405,089.00 | 84,270,117.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,225,500.00 | 1,225,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 14,000.00 | 14,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,044,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 62,121,589.00 | 83,030,617.00 |
| 35600 | Мал амьтад | 366,000.00 | 366,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,779,513,639.26 | 4,995,167,731.02 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,779,513,639.26 | 4,995,167,731.02 |
| 392 | Биет хөрөнгө | 5,631,173,014.30 | 4,839,139,706.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,494,246,079.87 | 4,675,791,534.77 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (422,041,976.49) | (453,864,063.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,000,000.00 | 26,420,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,000,000.00) | (21,000,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 221,760,168.88 | 365,577,732.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (110,474,026.13) | (138,397,283.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 177,167,048.00 | 186,760,498.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (72,887,180.24) | (105,415,272.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 413,363,060.00 | 422,391,733.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (77,509,279.59) | (130,964,292.87) |
| 39217 | Ном | 7,549,120.00 | 11,839,120.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 148,340,624.96 | 156,028,024.96 |
| 39301 | Програм хангамж | 2,340,000.00 | 10,027,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,663,375.04) | (1,663,375.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 147,664,000.00 | 147,664,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,887,039,328.68 | 5,109,047,829.29 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 5,319,622.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 5,319,622.00 |
| 413 | Өглөг | - | 5,319,622.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2,868,622.00 |

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 2,451,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,887,039,328.68 | 5,103,728,207.29 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,887,039,328.68 | 5,103,728,207.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 503,776,882.44 | 503,776,882.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 503,776,882.44 | 503,776,882.44 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 4,406,233,800.42 | 4,102,815,774.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,406,233,800.42 | 4,886,126,896.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (783,311,121.39) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 977,028,645.82 | 497,135,549.87 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,887,039,328.68 | 5,109,047,829.29 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 7,028,060,863.53 | 1,345,505,263.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,085,771,235.53 | 351,718,463.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,085,771,235.53 | 351,718,463.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 172,775,598.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 172,775,598.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,982,377,944.53 | 158,848,837.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 102,031,051.00 | 20,094,028.00 |
| 120009 | Бусад орлого | 1,362,240.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 942,289,628.00 | 993,786,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 679,787,900.00 | 771,562,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 679,787,900.00 | 771,562,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 35,535,428.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,576,828.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,473,500.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,485,100.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 226,966,300.00 | 222,224,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 226,966,300.00 | 222,224,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,141,021,534.85 | 1,479,249,285.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,141,021,534.85 | 1,479,249,285.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,063,926,171.21 | 1,305,426,597.14 |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 480,933,174.94 | 594,400,489.15 |
| 210101 | Үндсэн цалин | 354,596,887.21 | 363,976,930.34 |
| 210102 | Нэмэгдэл | 93,721,312.77 | 198,129,141.23 |
| 210104 | Урамшуулал | 32,614,974.96 | 32,294,417.58 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 63,969,700.00 | 71,070,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,505,600.00 | 48,328,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,116,000.00 | 5,685,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,093,000.00 | 4,548,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,161,000.00 | 1,136,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,094,100.00 | 11,371,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 183,072,969.00 | 218,925,961.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,801,984.00 | 10,375,345.85 |
| 210302 | Түлш, халаалт | 160,874,340.00 | 192,879,866.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,396,645.00 | 15,670,750.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,048,630.00 | 7,098,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,547,130.00 | 4,566,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,501,500.00 | 2,531,950.00 |
| 2105 | Нормативт зардал | 38,025,700.00 | 79,949,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,025,700.00 | 79,949,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,798,162.00 | 3,199,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,798,162.00 | 3,199,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,273,340.00 | 4,379,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,515,100.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,758,240.00 | 4,379,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,804,495.27 | 326,402,246.14 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,298,250.00 | 6,536,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,049,100.00 | 5,249,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 224,457,145.27 | 314,615,896.14 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 77,095,363.64 | 173,822,688.15 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,830,228.00 | 173,724,250.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 39,726,300.00 | 35,238,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,103,928.00 | 138,486,250.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 14,265,135.64 | 98,438.15 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,265,135.64 | 98,438.15 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 5,887,039,328.68 | (133,744,022.29) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 649,567,099.10 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 649,567,099.10 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (649,567,099.10) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 5,887,039,328.68 | (783,311,121.39) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 943,651,868.00 | 1,166,562,398.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,362,240.00 | 172,775,598.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,362,240.00 | 172,775,598.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 172,775,598.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 172,775,598.00 |
| 120009 | Бусад орлого | 1,362,240.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 942,289,628.00 | 993,786,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 679,787,900.00 | 771,562,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 679,787,900.00 | 771,562,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 35,535,428.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,576,828.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,473,500.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,485,100.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 226,966,300.00 | 222,224,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 226,966,300.00 | 222,224,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 885,218,167.58 | 1,157,083,867.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 885,218,167.58 | 1,157,083,867.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 804,613,003.94 | 985,390,179.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 480,933,174.94 | 591,531,867.15 |
| 210101 | Үндсэн цалин | 354,596,887.21 | 361,108,308.34 |
| 210102 | Нэмэгдэл | 93,721,312.77 | 198,129,141.23 |
| 210104 | Урамшуулал | 32,614,974.96 | 32,294,417.58 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 63,969,700.00 | 71,070,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,505,600.00 | 48,328,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,116,000.00 | 5,685,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,093,000.00 | 4,548,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,023,100.00 | 1,136,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,232,000.00 | 11,371,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 183,072,969.00 | 218,925,961.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,801,984.00 | 10,375,345.85 |
| 210302 | Түлш, халаалт | 160,874,340.00 | 192,879,866.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,396,645.00 | 15,670,750.00 |

| | | | |
|-------------|--|------------------------|------------------------|
| 2105 | Нормативт зардал | 33,473,000.00 | 76,582,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,473,000.00 | 76,582,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,997,500.00 | 3,199,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,997,500.00 | 3,199,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,761,080.00 | 4,379,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,761,080.00 | 4,379,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,405,580.00 | 19,700,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,178,980.00 | 13,126,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,226,600.00 | 6,573,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,605,163.64 | 171,693,688.15 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 66,340,028.00 | 171,595,250.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,236,100.00 | 33,109,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,103,928.00 | 138,486,250.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 14,265,135.64 | 98,438.15 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,265,135.64 | 98,438.15 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 58,433,700.42 | 9,478,530.85 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 21,590,000.00 | 20,988,250.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 21,590,000.00 | 20,988,250.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 21,590,000.00 | 20,988,250.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 21,590,000.00 | 20,988,250.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (21,590,000.00) | (20,988,250.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 36,843,700.42 | (11,509,719.15) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 36,843,700.42 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 36,843,700.42 | 25,333,981.27 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 503,776,882.44 | 977,028,645.82 | 4,406,233,800.42 | 5,887,039,328.68 |
| 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 503,776,882.44 | 977,028,645.82 | 4,406,233,800.42 | 5,887,039,328.68 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 479,893,095.95 | 479,893,095.95 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 503,776,882.44 | 977,028,645.82 | 4,886,126,896.37 | 6,366,932,424.63 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (479,893,095.95) | - | (479,893,095.95) |

| | | | | |
|--|-----------------------|-----------------------|-------------------------|-------------------------|
| Тайлант үеийн үр дүн | - | - | (783,311,121.39) | (783,311,121.39) |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 503,776,882.44 | 497,135,549.87 | 4,102,815,774.98 | 5,103,728,207.29 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-----------------------|--|-------------------------|-------------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,264,734,600.00 | 1,178,072,117.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,264,734,600.00 | 1,178,378,429.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,044,974,200.00 | 1,006,378,429.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 601,271,400.00 | 591,531,867.15 |
| 210101 | Үндсэн цалин | 409,781,900.00 | 361,108,308.34 |
| 210102 | Нэмэгдэл | 159,796,700.00 | 198,129,141.23 |
| 210104 | Урамшуулал | 31,692,800.00 | 32,294,417.58 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 75,159,100.00 | 71,070,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,108,100.00 | 48,328,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,012,700.00 | 5,685,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,810,200.00 | 4,548,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,202,600.00 | 1,136,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,025,500.00 | 11,371,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 236,905,700.00 | 218,925,961.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,266,800.00 | 10,375,345.85 |
| 210302 | Түлш, халаалт | 205,623,700.00 | 192,879,866.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,015,200.00 | 15,670,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 79,146,400.00 | 76,582,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 79,146,400.00 | 76,582,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,200,000.00 | 3,199,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,200,000.00 | 3,199,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,412,500.00 | 4,379,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,030,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,382,500.00 | 4,379,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,879,100.00 | 40,688,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,305,300.00 | 34,114,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,573,800.00 | 6,573,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 219,760,400.00 | 171,595,250.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 219,760,400.00 | 171,595,250.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,020,900.00 | 33,109,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 178,739,500.00 | 138,486,250.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 98,438.15 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 98,438.15 |

| | | | |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,264,734,600.00 | 1,166,562,398.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 811,435,100.00 | 771,562,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 811,435,100.00 | 771,562,500.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 240,105,700.00 | 222,224,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 240,105,700.00 | 222,224,300.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 213,193,800.00 | 172,775,598.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 213,193,800.00 | 172,775,598.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 36,843,700.42 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 25,333,981.27 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 39 | 35 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 20 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 14 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122,911.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 6,781.3 мянган төгрөгийн алдааг залруулаагүй байна.

Залруулсан алдаа:

- НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, УСНББОУС-1, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

Аудитаар нийт 8,427.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,107.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,319.6 мянган төгрөгийн албан шаардлага тогтоож, “НББ-ийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн батлах тухай зөвлөмж өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|----------------|----------|----------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд нийт зарлага ба цэвэр зээлийн дүн нь зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг зөрүүтэй тайлагнасан | 1 | 95,142.2 | | | 1 | 95,142.2 | 1 | 95,142.2 | | | | |
| "Мөнгөн гүйлгээний тайлан"-ийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан дүн "Үндсэн хөрөнгийн тайлан"-ийн худалдан авсан дүнгээс зөрүүтэй тайлагнасан | 1 | 20,988.3 | | | 1 | 20,988.3 | 1 | 20,988.3 | | | | |
| Цалингийн тооцооллыг "Санхүүгийн үр дүнгийн тайлан"-ийн цалингийн зардалтай тулгахад зөрүүтэй тайлагнасан | 1 | 6,781.3 | | | 1 | 6,781.3 | | | 1 | 6,781.3 | 1 | 6,781.3 |
| Дүн | 3 | 122,911.8 | | | 3 | 122,911.8 | 2 | 116,130.5 | 1 | 6,781.3 | 1 | 6,781.3 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|---------|---------------|---------|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 3 ажилтанд 1,192.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс илүү олгосон | 1 | 1,192.9 | 1 | 1,192.9 | | | | | | | | |
| Дотуур байрны нэг суралцагчийн хоногийн хоолны зардлын нормативыг 1,914.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан | 1 | 1,914.8 | 1 | 1,914.8 | | | | | | | | |
| үйлдвэрчний эвлэл, хоол, бусад зардлын 5,319.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан | 1 | 5,319.6 | | | 1 | 5,319.6 | | | | | | |
| Цалин хөлсний бүртгэлд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжууд 2023 онд шинэчлэгдсэн бөгөөд Аймгийн | 1 | | | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|----------|----------------|----------|----------------|----------|----------------|----------|--|--|--|--|--|
| Засаг даргын 2018 оны А/393 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үндэслэн санхүүгийн бүртгэл хөтөлж, тайлан бэлтгэсэн | | | | | | | | | | | | |
| Дүн | 4 | 8,427.3 | 2 | 3,107.7 | 1 | 5,319.6 | 1 | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээ буюу 114,825.8 мянган төгрөгийг мэдээлээгүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан | 1 | 114,825.8 | | | 1 | 114,825.8 | | |
| Дүн | 1 | 114,825.8 | | | 1 | 114,825.8 | | |